



СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

148 /148/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.10.04

Үйл явдал

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 015 ДУГААР АНГИ ХУРАНДАА О.СЭРДАРЫН НЭРЭМЖИТ БОЛЛОО



ТүүнийохинС.Гантөмөрийн хэлснээр "Өнөөдөр аавын минь ажил үйлс, гавьяа зүтгэлийг төр засаг, батлан хамгаалах салбар өндрөөр үнэлж, Зэвсэгт хүчний 015 дугаар ангийг нэрэмжит болгон мөнхжүүлж байгаад үр хүүхдүүд бид маш их баяртай байна. Энэ хүний үргэлжлэл болж өдий хүрч байгаагаараа бахархах сэтгэл өөрийн эрхгүй төрж байна. Миний аав зарчимч, шулуун шударга, хамгийн гол нь хүнийг их хүндэлдэг байснаас харахад ёстой л цэргийн дарга хүнд л байхаар зан чанарыг цогцлоож дээ гэж хожим бодогддог юм. Аав минь өнөөдрийн энэ үйл явдлыг тэнгэрээс харж байгаа гэдэгт итгэлтэй байна" гэсэн юм.

Энэ жил Монгол Улсын батлан хамгаалах салбарын хувьд олон түүхэн ой тохиож байгаагийн нэг нь Зэвсэгт хүчний 015 дугаар анги 100 дахь жилийнхээ босгыг давсан явдал юм. Энэ хүрээнд тус ангийг Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн 285 дугаар тогтоолоор Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн, хурандаа Осорын Сэрдарын нэрэмжит болгосон юм. Харин өнгөрсөн Баасан гарагт эл тогтоолыг ангийн захирагч,

хурандаа Ц.Батсайханд албан ёсоор гардуулан өгч, О.Сэрдар агсны алдар, гавьяаг нийт бие бүрэлдэхүүнд уншиж танилцуулсан юм.

Энэхүү ёслолын үйл ажиллагаанд БХЯ-ны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, хурандаа Ч.Гандирваа, Зэвсэгт хүчний Материал, техникийн газрын дарга, бригадын генерал М.Мөнхбаяр нар болон П.Сэрдар агсны гэр бүлийн төлөөллөөс оролцлоо.



Бираме Диоп: "ЖУБА БҮСИЙН КОМАНДЛАЛЫН УДИРДЛАГЫН ГАР НИЙЛЭМЖТЭЙ АЖИЛЛАГААНД СЭТГЭЛ ХАНГАЛУУН БАЙНА"

Жуба бүсийн командлагч, бригадын генерал Б.Эрдэнэбат ажиллагааны газар оронд аюулгүй байдлыг дээшлүүлэн илэнгийн иргэдийн айдасгүйгээр амьдрах орчинг бүрдүүлэх зорилгоор Жуба хот-Нимуле хотыг холбосон эдийн засгийн ач холбогдол бүхий хангалтын төв зам дагуу байрлах "Ару уулзвар"-т Руанда Улсын I мотобуудлагын батальоноос холын эргүүлийн бүлэг томилон үүрэг гүйцэтгүүлэв.

Энэ үеэр цэргийн багийн үүрэг гүйцэтгэлт болон түр ажиллагааны баазтай танилцахаар Хүчний командлагч, дэслэгч генерал Шайлиш Тинайкар болон бусад албаны төлөөлөгч нартай хамт 9 дүгээр сарын 28-ны өдөр айлчлав.

Уганда Улсаас ирэх бүх төрлийн хангалтын цуваа руу зэвсэгт бүлэг ачаа барааг дээрэмдэх, отолт хийх зөрчлүүд гарч байгаа нь Өмнөд Судан Улсын ард түмний амьжиргаанд ихээхэн хүнд цохилт болж байгаа тул Жуба бүсийн хариуцлагын бүсэд



холын эргүүл зохион байгуулж хөдөлгөөнийг хэвийн үргэлжлүүлэх бололцоог ханган ажиллаж байгаа юм. Бүсийн командлагч, бригадын генерал Б.Эрдэнэбат орон нутгийн иргэдтэй уулзаж, тэдний өмнө тулгарч буй бэрхшээлүүд, үе үе

гардаг зөрчилдөөн, гэмт хэргийн гаралтын шалтгаан зэрэгтэй танилцан эдгээрийг бууруулахын тулд хамтран ажиллах боломжийн талаар ярилцав.

Мөн энэ долоо хоногт БНӨСУ-д явагдаж байгаа энхийг сахиулах

ажиллагаатай танилцахаар Нью-Йорк дахь НҮБ-ын Энхийн сахиулах ажиллагааны газрын Цэргийн зөвлөх, Сенегал Улсын генерал Бираме Диоп 2021 оны 10 дугаар сарын 2-6-ны хооронд албан ёсны ажлын айлчилж хийж байна.

Лүргэлжлэл нь арын нүүрт!

Түүхэнд энэ өдөр

1929 он:

Засгийн газрын 32 дугаар хурлын тогтоолоор олон аймаг хошуудын цэргийн хэлтсийн эрхэлсэн түшмэд нарыг цэргийн хэлтсийн дарга хэмээн нэрийдэх болжээ.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
8	-2

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
32	21

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,848.00	2,851.00
EUR	3,305.0	3,325.0
CNY	441.3	442.0
RUB	38.60	40.30
JPY	25.35	25.93
KRW	2.32	2.44

ЗУРХАЙ

2021.10.04 БААСАН ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 28/

НАМРЫН ДУНД УЛААГЧИН ТАХИА САРЫН НЭГ ЦАГААН ХӨХӨГЧИН ТАХИА ӨДӨР

Үс засуулбал:

Хэрүүл тэмцэл ирнэ

Наран ургах, шинжих:

06.56-18.26

Барилдлага:

Үхэх

Шүтэн барилдлага:

Сэрэхүй

Суудал:

Уул

Тухайн өдөр нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, бие энхрийлүүштэй. Эл өдөр гэмт хэрэг илрүүлэх, гэм буруутныг шийтгэх, лусыг тахиж, андгай тангараг, гэрээ, хэлцлээ буцаахад сайн.

Гэр бүрэх, хэрүүл тэмцэл хийх, сэтгэлд сэтгэй газар очих, хүүхэд хөлд оруулахад муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой. Хол газар яваар одогсод баруун урагш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН
305.327 +1811

ЭДГЭРСЭН
346.847 +6780

НАС БАРСАН
1260 +19

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН
5350 +90

ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БҮЙ
184

ЭДГЭРСЭН
5063

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 235,699,920

Эдгэрсэн

Нийт: 212,557,440

Нас барсан

Нийт: 4,815,521



АХМАД ДАЙЧДАД ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ УЛС ДАЯАР ЯВАГДЛАА

Өнгөрсөн 9 дүгээр сарын 20, 21-ний өдрүүдэд Улаанбаатарт амьдардаг 24 ахмад дайчны оршин суугаа газрын орчимд очиж, халдвар хамгааллын дэглэм сахин, хүндэтгэл үзүүлсэн билээ.

Монгол Улсын ЗХЖШ болон “Эх орны дайчид” НҮТББ хамтран Зэвсэгт хүчний 100, Чөлөөлөх дайны ялалтын 76, Олон улсын ахмадын өдрийг тохиолдуулан “Халхын голын дайн”, 1945 оны “Чөлөөлөх дайн”, 1940-1948 онд Улсын баруун хилд болсон зэвсэгт тулгаралт оролцож байсан ахмад дайчдад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээ энэ удаад улс даяар явагдлаа. Тодруулбал, 18 аймагт

оршин суудаг 31 ахмад дайчинд тухайн аймгийн Цэргийн штаб, тэнд байрлах Зэвсэгт хүчин болон Хилийн цэргийн ангиудын хүчээр нэгэн зэрэг хүндэтгэл үзүүлсэн юм.

Энэ хүрээнд хөдөө орон нутагт оршин суудаг, нийслэл Улаанбаатар хотод ирээд буй Тогоочийн Лувсансүх, Намсрайн Пүрэвжалаа, Батчулууны Ядамсүрэн, Бүрkitбайн Сейлхан нарт хүндэтгэл үзүүлж, ЗХЖШ-ын ҮЖҮНХ болон ЦДБЭЧ-аастомилогдсон бүрэлдэхүүн урлаг уран сайхнаар үйлчиллээ.

“Эх орны дайчид” НҮТББ-ын тэргүүн Р.Баяр энэ үеэр “Монгол Улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт

байдал, улсын хилийн халдашгүй дархан байдал, өнөө цагийн амар тайван амьдралын төлөө халуун амь, бүлээн цусаа үл хайрлан тэмцэж явсан таны байгуулсан гавьяа, хатан зориг, туулж өнгөрүүлсэн амьдрал, тусгаар тогтнолын үнэ цэнийг үр хойч бид үеийн үед мартаж үл болно” гэв.

Ахмад дайчид Байлдааны туганд хүндэтгэл үзүүлэхийн зэрэгцээ энэхүү арга хэмжээг зохион байгуулсан ЗХЖШ-ын бие бүрэлдэхүүн болон “Эх орны дайчид” НҮТББ-ын хамт олонд талархал илэрхийлээд Зэвсэгт хүчний нийт бие бүрэлдэхүүндээ эрүүл энх, амжилт бүтээлийг хүсэн ерөөв.



“ЦЭРГИЙН ДҮЙЦҮҮЛЭХ АЛБАНЫ БЭЛТГЭЛ” СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Говь-Алтай аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб

Цэргийн дүйцүүлэх албыг 2021 онд биеэр хаах иргэдийг Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Цэргийн албыг дүйцүүлэн хаах журам”, 2020 оны 72 дугаар тогтоолыг тус тус үндэслэн сум, багаас цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах хүсэлт гаргасан иргэдийн материалыг хүлээн авч,

аймгийн Засаг даргын 2021 оны А/369 дүгээр захирамжийн дагуу цэргийн дүйцүүлэх албанд 40 иргэнийг элсүүлж, Батлан хамгаалахын сайдын 2018 оны “Сургалтын хөтөлбөр, мэдээний маягт батлах тухай” А/211 дүгээр тушаалаар батлагдсан “Цэргийн дүйцүүлэх албаны бэлтгэл” сургалтын хөтөлбөрийн дагуу хичээлийн хөтөлбөр төлөвлөгөөг боловсруулан нийт 110 цагийн сургалтыг

зохион байгуулав. Бэлтгэл ажлыг Эрүүл мэндийн яам, Улсын онцгой комисс, аймгийн онцгой комиссоос гаргасан заавар, зөвлөмж, ариутгал, халдваргүйжүүлэлтийн дэглэмийг баримтлан аймгийн Онцгой байдлын газрын материаллаг баазыг түшиглэн 2021 оны 9 дүгээр сарын 15-28-ны өдрийг дуустал 14 хоногийн хугацаатай зохион байгууллаа.

Ахмад Г.МӨНХБАЯР



Бираме Диоп: "ЖУБА БҮСИЙН КОМАНДЛАЛЫН УДИРДЛАГЫН ГАР НИЙЛЭМЖТЭЙ АЖИЛЛАГААНД СЭТГЭЛ ХАНГАЛУУН БАЙНА"



/Түрүүч нь эхний нүүрт/

Айлчлалын хүрээнд Жуба бүсийн командлагч, бригадын генерал Б.Эрдэнэбат Цэргийн зөвлөх, генерал Бираме Диоп, Хүчний командлагч болон дагалдан явж буй албаны бусад төлөөлөгчийг өөрийн штабын байрлалд хүлээн авч Жуба бүсийн үйл ажиллагааны талаар танилцуулга хийж, өөрийн

авч хэрэгжүүлсэн шинэ дэвшилтэт ажлын арга барил болон тулгамдаж буй асуудлын талаар танилцуулав.

Айлчлалын төгсгөлд генерал Бираме Диоп хэлсэн үгэндээ Жуба бүсийн командлалын удирдлагын гар нийлэмжтэй ажиллагаа, цэргийн багууддаа нэгдсэн нэг удирдлагаар хангаж, сахилга зохион

байгуулалтай, цэргийн сэтгэл зүйг байнга дэмжиж, үүрэг гүйцэтгэх нөхцөлийг анхааран ажиллаж байгаад талархаад, эмэгтэй энхийг сахиулагчдын оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээг тусгайлан сайшааж бусад улс оронд явагдаж байгаа энхийг сахиулах ажиллагаанд үлгэр жишээ болохыг санал болгов.

Хошууч Н.ГАНТУЛГА



Дарга, ерөнхий редактор, хурандаа САНЖМЯТАВЫН ТӨМӨРХҮЯГ



ЦАХИМ ХАЯГ

Батлан хамгаалах яам
Зэвсэгт хүчний Жанжин штаб



ЦАХИМ ХУУДАС

"Соёмбо" сонин
"Дуулга" студи

* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.
* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.
* Тус сонин мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон
Индекс: 10018

Цахим шуудан:
Soymbo@mod.gov.mn
Утас: 70001029, 3412 (дотуур)